



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бөөнцагаан Орог нуурын сав газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/174/НА-СТА-ТШЗ

<p>Баянхонгор 2022 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn</p>
-------------------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Төлбөрийн акт	14
4.3 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.18

№ 2/25

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөөнцагаан Орог нуурын сав газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөөнцагаан Орог нуурын сав газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D- alban bichig 2022 A4 TOOT

005020246

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,249,075.00	28,284,238.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	8,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	8,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	17,249,075.00	20,284,238.00
351	Түүхий эд материал	9,615,880.00	9,212,330.00
35110	Тусгай зориулалттай материал	9,615,880.00	9,212,330.00
354	Хангамжийн материал	7,633,195.00	11,071,908.00
35410	Бичиг хэргийн материал	839,000.00	828,000.00
35420	Аж ахуйн материал	3,785,397.00	4,584,499.00
35430	Сэлбэг хэрэгсэл	215,000.00	2,900,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,708,798.00	2,124,409.00
35470	Бусад хангамжийн материал	85,000.00	635,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,039,434.46	60,368,145.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,039,434.46	60,368,145.14
392	Биет хөрөнгө	20,039,434.46	60,368,145.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,855,500.00	76,495,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-31,896,000.00	-32,287,899.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,435,766.00	54,457,041.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-36,138,398.67	-41,793,375.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,856,884.39	12,856,884.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,074,317.26	-9,360,005.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	195,000.00	00.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-195,000.00	00.00
39301	Программ хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	37,288,509.46	88,652,383.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	85,083.12
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	85,083.12
413	Өглөг	00.00	85,083.12
4136	Бусад өглөг	00.00	85,083.12
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	37,288,509.46	88,567,300.02
51	Засгийн газрын хувь оролцоо	37,288,509.46	88,567,300.02
512	Хуримтлагдсан үр дүн	37,288,509.46	88,567,300.02
51210	Өмнөх үеийн үр дүн	37,288,509.46	37,288,509.46
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	51,278,790.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	37,288,509.46	88,652,383.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	201,450,407.00	248,201,265.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,181,621.00	44,637,465.52
120	Нийтлэг татварын бус орлого	12,181,621.00	44,637,465.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,181,621.00	44,637,465.52
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	223,900.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,957,721.00	44,637,465.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	189,268,786.00	203,563,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	178,404,500.00	170,363,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	178,404,500.00	170,363,800.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,864,286.00	33,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,150,000.00	33,200,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	199,367,255.46	196,922,474.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	199,367,255.46	196,922,474.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	170,260,430.75	180,661,153.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107,186,744.00	111,431,927.00
210101	Үндсэн цалин	107,186,744.00	111,431,927.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,168,792.29	15,825,386.88
210201	Тэтгэврийн даатгал	10,393,706.12	11,240,626.48
210202	Тэтгэмжийн даатгал	1,162,900.00	1,146,190.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	993,930.70	916,952.48
210204	Ажилгүйдлийн даатгал	249,833.18	229,238.42
210205	Эрүүл мэндийн даатгал	1,368,422.29	2,292,378.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,947,000.00	8,820,000.00
210304	Байрны түрээс	8,947,000.00	8,820,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,273,789.00	9,371,616.00
210401	Бичиг хэрэг	2,474,200.00	1,344,900.00
210402	Тээвэр, шатахуун	8,015,193.00	4,425,779.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,148,096.00	826,839.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,648,800.00	1,093,200.00
210408	Бараа материал акталсны зардал	987,500.00	1,680,898.00
2105	Нормативт зардал	100,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,088,500.00	392,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	130,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	695,400.00	262,950.00
210604	Урсгал засвар	6,393,100.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	3,094,500.00	3,106,800.00
210702	Дотоод албан томилолт	3,094,500.00	3,106,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,394,950.00	24,379,909.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,740,550.00	23,705,317.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,000.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	86,400.00	140,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	222,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,006,155.46	7,332,564.84
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,006,155.46	7,332,564.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,106,824.71	16,261,321.24
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,020,538.71	1,334,300.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,020,538.71	1,334,300.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	86,286.00	14,927,021.24
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,286.00	14,927,021.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,083,151.54	51,278,790.56
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,083,151.54	51,278,790.56

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	189,492,686.00	203,563,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	223,900.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	223,900.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	223,900.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	223,900.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	189,268,786.00	203,563,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	178,404,500.00	170,363,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	178,404,500.00	170,363,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,864,286.00	33,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,150,000.00	33,200,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	188,853,786.00	200,063,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	188,853,786.00	200,063,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	159,746,961.29	183,802,478.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	105,548,923.63	111,740,057.90
210101	Үндсэн цалин	83,094,628.63	84,460,949.90
210102	Нэмэгдэл	15,849,295.00	20,024,108.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,605,000.00	7,255,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,493,935.66	15,432,172.86
210201	Тэтгэврийн даатгал	9,991,935.03	10,847,412.46
210202	Тэтгэмжийн даатгал	1,242,700.00	1,146,190.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	993,930.70	916,952.48
210204	Ажилгүйдлийн даатгал	248,500.00	229,238.42
210205	Эрүүл мэндийн даатгал	2,016,869.93	2,292,378.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,947,000.00	8,820,000.00
210304	Байрны түрээс	8,947,000.00	8,820,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,252,496.00	6,320,439.00
210401	Бичиг хэрэг	1,508,200.00	857,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,647,500.00	3,173,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,448,096.00	1,197,839.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,648,700.00	1,092,200.00
2105	Нормативт зардал	624,499.00	624,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	624,499.00	624,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,856,400.00	866,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	510,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356,400.00	356,400.00
2107	Томилолт, зочны зардал	3,094,500.00	2,906,800.00
210702	Дотоод албан томилолт	3,094,500.00	2,906,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,929,207.00	37,092,609.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,274,807.00	36,390,017.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,000.00	79,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	86,400.00	140,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,106,824.71	16,261,321.24
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,020,538.71	1,334,300.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,020,538.71	1,334,300.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	86,286.00	14,927,021.24
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,286.00	14,927,021.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	638,900.00	3,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	638,900.00	3,500,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	638,900.00	3,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	638,900.00	3,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	638,900.00	3,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)-(4)-(5)	-638,900.00	-3,500,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	төгрөгөөр
			Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,205,357.92	35,205,357.92
C07	Тайлант үеийн үр дүн	2,083,151.54	2,083,151.54
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,288,509.46	37,288,509.46
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,288,509.46	37,288,509.46
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,288,509.46	37,288,509.46
D08	Тайлант үеийн үр дүн	43,168,873.68	43,168,873.68
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,457,383.14	80,457,383.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	170,363,800.00	155,436,778.76	14,927,021.24	91.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	170,363,800.00	155,436,778.76	14,927,021.24	91.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	170,363,800.00	155,436,778.76	14,927,021.24	91.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,262,500.00	111,740,057.90	12,522,442.10	89.9
210101	Үндсэн цалин	88,572,100.00	84,460,949.90	4,111,150.10	95.4
210102	Нэмэгдэл	29,004,000.00	20,024,108.00	8,979,892.00	69.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,686,400.00	7,255,000.00	-568,600.00	108.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,775,400.00	15,432,172.86	1,343,227.14	92.0
210201	Тэтгэврийн даатгал	11,804,900.00	10,847,412.46	957,487.54	91.9
210202	Тэтгэмжийн даатгал	1,242,600.00	1,146,190.90	96,409.10	92.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	994,100.00	916,952.48	77,147.52	92.2
210204	Ажилгүйдлийн даатгал	248,500.00	229,238.42	19,261.58	92.2
210205	Эрүүл мэндийн даатгал	2,485,300.00	2,292,378.60	192,921.40	92.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,839,300.00	8,820,000.00	19,300.00	99.8
210304	Байрны түрээс	8,839,300.00	8,820,000.00	19,300.00	99.8
2104	Хангамж, бараа материалын зардал	6,423,200.00	6,320,439.00	102,761.00	98.4
210401	Бичиг хэрэг	857,400.00	857,400.00	00.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,213,300.00	3,173,000.00	40,300.00	98.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,260,300.00	1,197,839.00	62,461.00	95.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,092,200.00	1,092,200.00	00.00	100.0
2105	Нормативт зардал	624,500.00	624,000.00	500.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	624,500.00	624,000.00	500.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	867,500.00	866,400.00	1,100.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	511,100.00	510,000.00	1,100.00	99.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356,400.00	356,400.00	00.00	100.0
2107	Томиллолт, зочны зардал	2,935,000.00	2,906,800.00	28,200.00	99.0
210702	Дотоод албан томилолт	2,935,000.00	2,906,800.00	28,200.00	99.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,636,400.00	8,726,909.00	909,491.00	90.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,910,200.00	8,024,317.00	885,883.00	90.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	88,800.00	79,500.00	9,300.00	89.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,000.00	140,092.00	7,908.00	94.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	39,400.00	33,000.00	6,400.00	83.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	170,363,800.00	155,436,778.76	14,927,021.24	91.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	170,363,800.00	155,436,778.76	14,927,021.24	91.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	170,363,800.00	155,436,778.76	14,927,021.24	91.2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	10.00	10.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,778,000.00	31,865,700.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,778,000.00	31,865,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,778,000.00	31,865,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,778,000.00	31,865,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,778,000.00	31,865,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,778,000.00	31,865,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,864,286.00	31,865,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,864,286.00	31,865,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,286.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,150,000.00	31,865,700.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бөөнцагаан Орог нуурын сав газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөөнцагаан Орог нуурын сав газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 1 дүгээр сарын 24 өдрийн 30 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Бөөнцагаан Орог нуурын сав газрын даргын үүргийг түр орлог гүйцэтгэгч Г.Хүрэлсүх, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Ичинхорлоо нар зурж байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бөөнцагаан Орог нуурын сав газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сав газрын хэмжээнд усны нөөцийг хомсдол бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, орон нутгийн салбар дундын зохицуулалтыг хангах усны нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны “Хяналт, шинжилгээ, дотоод аудитын газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Бөөнцагаан Орог нуурын сав газар 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөөнцагаан Орог нуурын сав газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 376,382.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,645.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,952.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 3,072.6 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бөөнцагаан Орог нуурын сав газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,363.9 мянган төгрөгөөр буюу 137.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,249.1	28,284.2	11,035.2
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	8,000.0	8,000.0
Бараа материал	17,249.1	20,284.2	3,035.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,039.4	60,368.1	40,328.7
Үндсэн хөрөнгө	97,113.2	144,579.4	47,466.3
Хуримтлагдсан элэгдэл	(77,073.7)	(84,211.3)	(7,137.6)
Нийт хөрөнгө	37,288.5	88,652.4	51,363.9
Өр төлбөр	-	85.1	85.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	37,288.5	88,567.3	51,278.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	37,288.5	88,652.4	51,363.9

Урьдчилж гарсан зардал /авлага/ данс нь 8,000.0 мянган төгрөгөөр байгаа нь Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газрын усны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх зардалд урьдчилж 8,000.0 шилжүүлснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 20,284.2 мянган төгрөг болж 3,035.2 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, сэлбэг хэрэгслийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 144,579.4 мянган төгрөг болж 47,466.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2021.09.20-ны өдрийн А/283 дугаар тушаалаар 42,640.0 мянган төгрөгийн өртөгтэй Уаз фургон автомашин үнэ төлбөргүй шилжүүлж авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 85.1 мянган төгрөг болж 85.1 төгрөгөөр өссөн нь урьд оны санхүүгийн тайлангийн зөвлөмжөөр мэргэжилтэн Э.Жамцын НДШ-ийг нөхөн мэдээлж шилжүүлээгүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 88,567.3 мянган төгрөг болж 51,278.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 51278.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 207,041.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 207,041.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 29,310.2 мянган төгрөгөөр бууруулж 177,731.7 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 178,404.5 мянган төгрөг болгож 672.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 170,363.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 170,363.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 170,363.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 155,436.8 мянган төгрөгийг зарцуулж 14,927.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 155,436.8 мянган төгрөг буюу 99.97 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 12,522.4 мянга, ажил олгогчоос төлөх НДШ-ээс 1,343.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 19.3 мянга, хангам бараа материалын зардлаас 102,8 төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 33,200.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 31,865.7 мянган төгрөгийг зарцуулж 1,334.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн ба дээд шатны төсвийн захирагчаас 25,000.0 мянган төгрөгийн орлогоос голын голдиролд үзлэг хийж далан байгуулах ажилд 9,365.5 мянга, усны тоо бүртгэлийн ажилд 14,500.2 мянган төгрөг тус тус зарцуулж 1,134.3 мянган төвлөрүүлсэн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын дансанд усны менежментийн төлөвлөгөөний төлбөрт 8,000.0 мянган төгрөг, усны дүгнэлтийн хөлс 200.0 мянга нийт 8,200.0 мянган төгрөгийн орлого орж Бөөнцагаан нуур-Байдраг голын Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулах зардалд 8,000.0 мянган төгрөгийг зарцуулж 200.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд гэрээт аудитор Г.Ганчимэг аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 13 зорилтын хүрээнд 28 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 248,201.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 46,750.8 мянган төгрөгөөр буюу 23.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр тус тус нэмэгдсэн, хангамж бараа материалын зардал, эд хогшил урсгал засварын зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10

төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 200,616.1 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 141 мэдээллийг хугацаанд нь байршуулж 8 мэдээллийг

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	7	2	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	30	6	
5	Тухай бүр	8	96	96	0	
	Нийт	27	151	141	8	2

хугацаа хоцроож байршуулсан ба цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 42,888.2 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Тайлант онд 170,363.8 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 155,436.8 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 14,927.0 мянган төгрөг буюу төсвийн 0.5 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 17829,2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн хэрэгжилтийг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргааны даргын 2021.06.15-ны өдрийн 51 тоот албан бичгээр ирүүлснээр хэрэгжилтийг тооцсон байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,563.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,323.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 1239.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, алдаа, зөрчил давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

1.Нэмэлт санхүүжилтийн дансанд усны менежментийн төлбөрт 2021.08.06-нд Вояжер минерал ресурсес ХХК-аас 4000.0 мянга, 2021.09.09-нд Наранмандал Энтерпрайзес ХХК-аас 4000.0 мянган төгрөг төвлөрүүлснийг Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газрын усны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх 18000.0 мянган төгрөгийн гэрээг Монхидроконстракшн ХХК-тай 2021.11.18-ны өдөр байгуулж 2021.11.22-ны өдөр урьдчилгаа төлбөр болох 8000.0 мянган төгрөгийг шилжүүлж санхүүгийн тайланд урьдчилгаа тооцооны дансанд тусгалгүй шууд зардлын дансанд бичсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө", 14.3.1 "анхан шатны баримт бүрдүүлэх", 14.3.2 "журналд бичих", Санхүү, эдийн

засгийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ийн мөнгөн хөрөнгийн бүртгэлийг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилж гарсан зардлын авлага дансанд бичиж санхүүгийн тайланд залруулав.

2. Цалингийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгахдаа 323.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө”, Санхүү, эдийн засгийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ийн ажиллагсадтай холбогдсон зардлын бүртгэлийг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалингийн зардлыг нэмэгдүүлж, НДШ-ийн зардлын дансыг бууруулж залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогч С.Мөнхбаатар нь Бөөнцагаан Орог нуурын сав газартай гэрээгээр ажиллаж байх хугацаандаа Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2021.06.15-ны өдрийн А/140 дугаар тушаалыг үндэслэн Бөөнцагаан сав газрын захиргааны даргын 2021.07.23-ны өдрийн Б/03 дугаар тушаалаар 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан зөрчилгүй санал дүгнэлт авсан тул 160 хувийн нэмэгдэл, мөн хагас жилийн ур дүнгийн урамшуулалд 75 хувь нийт 235 хувийн нэмэгдэлд 1,659.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь ЗГ-ын тогтоолоор мөнгөн урамшуулал хувь хэмжээг зөрчсөн, мөн Нягтлан бодогч С.Мөнхбаатар нь тус сав газрын нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэдэг ба ХАОАТ-ын хөнгөлөлт эдэлж 144.8 мянган төгрөгийн дутуу суутгасан төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчдын мөнгөн урамшуулал олгох” журмын 2.2 хэсэгт “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.” Хувь хүний орлогын алба татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтад “Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”-д албан татвар ногдоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодогч С.Мөнхбаатараар цалингийн урамшууллын 155 хувийн зөрүү болох 1,095.1 мянга, ХАОАТ-ын хөнгөлөлтийн 144.8 мянга нийт 1,239.9 мянган төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2021 онд нийт 200,616.1 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 200616.1 мянган төгрөгийн 141 мэдээллийг хугацаанд нь байршуулж , 8 мэдээллийг

хугацаа хоцроож байршуулсан ба цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 42,888.2 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.1 Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогыг мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх

1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бөөнцагаан Орог нуурын сав газар	4	9,563.6	2	8,323.7	1	1,239.9	0	0	1	0

оОо